

М.ТАЧИБАНА “МОНГОЛЫН МАРТАГДСАН ТҮҮХ БОГД ХААНТ ЗАСГИЙН ГАЗАР (1911-1921)”

Нарангэрэл

Оршил

Уг номын зохиогч Тачибана Макото бол Монголын орчин үеийн түүхийн судалгааны талаар нэрд гарсан Японы залуу эрдэмтэн юм. 2010 онд Японы Васэда их сургуульд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд Японы эрдэм шинжилгээг дэмжих нийгэмлэг (JSPS)-ын тусгай судлаач болно. Тэрбээр 1999 оноос 2001 он хүртэл Монгол Улсын Шинжлэх ухааны Академи-д суралцаж, 2006 оноос 2008 он хүртэл Тайваний төв академийн Орчин үеийн түүхийн хүрээлэнд судлаачаар ажилласан бөгөөд 2011 оноос эхлэн Америкийн Индианагийн Их Сургуульд судалгааны ажил эрхэлж байна. Доктор М.Тачибана “Хоёр засгийн газартай 1921 оны Монгол” (УБ, 2006 он) хэмээх номыг Монгол хэлээр хэвлүүлсэн бөгөөд “Түмэн улсын ердийн цааз” (УБ, 2006 он), Монгол улсын үндэсний номын санд байгаа монгол гар бичмэл судрын гарчиг (Токио, 2011 он) зэрэг эмхтгэлийг хэвлүүлжээ. Мөн сүүлийн жилүүдэд олон өгүүлэл нийтлүүлж, ХХ зууны монгол түүхийн салшгүй нэг хэсэг болох Богд Хаант засгийн газрын тухай урьд урьдын судлалд орхигдсон буюу бүрхэгдсэн хэсгүүдийг анх удаа хөндөж судалжээ. Доктор М.Тачибана ном зохиолдоо хийсэн дүгнэлтүүдийн олонхи нь урьдчилсан судалгаанд хэн ч дурьдаагүй шинэ санаа байгаа юм. Түүний арваад жилийн турш цөхрөшгүй зүтгэсэн содон ажлынх нь нэг томоохон бүтээл гэвэл, “Богд Хаант засгийн газрын тухай судалгаа: Монгол улс байгуулагдсан түүх (1911-1921)” хэмээх ном болох бөгөөд үүгээр Монгол улсын түүхийн чухал нэг зурвас үеийг баттай тогтоон нэлээд хүнд асуудлыг боловсруулахад чухал хувь нэмэр оруулжээ гэдгийг энд онцлон тэмдэглэх ёстой.

Уг номыг Токио дахь Казамаан шиёбу хэмээх хэвлэлийн хорооноос 2011 онд хэвлүүлжээ. Уг номыг Японд хэвлэгдэхийн зэрэгцээ мөн 2011 онд монгол орчуулгыг “Монголын мартагдсан түүх” хэмээх нэрээр Улаабаатарт кирилл бичгээр хэвлүүлжээ. Цааш уг номыг “Богд хаант засгийн газрын тухай судлал” гэх буюу тус ном хэмээн товчилно. Мөн цааш “Зохиогч” гэвэл уг номын зохиогч Тачибана Макотог зааж, “Шүүмжлэгч” гэвэл тус шүүмж өгүүллийг туурвигч Нарангэрэлийг заана.

Тус зохиолын бүтэц дараах мэт.

Оршил

Нэгдүгээр бүлэг: Монголын тусгаар тогтнолын тунхаг

Хоёрдугаар бүлэг: Шинэ засгийн газрын гадаад дотоод байдал

Гуравдугаар бүлэг: Орос Монголын хэлэлцээр бүтсэн нь “Монгол” хэмээх үгийн эргэн тойронд

Дөрөвдүгээр бүлэг: Ханддорж тэргүүтэй төлөөлөгчид ба Хаант орос

Тавдугаар бүлэг: Орчин үеийн олон улсын нийгмийн хүрээнд орсон нь

Зургадугаар бүлэг: Өвөр Монголын дагаар орсон тухай асуудал Шилийн голын чуулганы жишээн дээр

Долдугаар бүлэг: Монголын тусгаар тогтнол ба Өвөр Монголын хандлага Зуу-Удын чуулганы жишээн дээр

Наймдугаар бүлэг: Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг өвөр Монголын талаас авч үзсэн нь Их-зуугийн чуулганы жишээн дээр

Есдүгээр бүлэг: Жарууд зүүн хошууны хоёр засгийн тогтолцоо

Аравдугаар бүлэг: Хишигтэн хошууны хоёр засгийн тогтолцоо

Арваннэгдүгээр бүлэг: Хорьдугаар зууны эхэн үеийн өвөр Монгол зүүн бүс нутгийн нийгмийн бүтэц Жирмийн чуулганы Горлос хойд хошууны жишээн дээр

Арванхоёрдугаар бүлэг: Орос Хятадын тунхаг ба Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчид

Арвангуравдугаар бүлэг: Хиагтын гэрээ ба дагаар орсон Монголчуудын хувь заяа

Арвандөрөвдүгээр бүлэг: Монголын хувьсгал

Дүгнэлт, Ном зүй, Англи хэлний товчлол, Хэлхээс

1. Зохиолын агуулга

Энд бүлэг тус бүрийн агуулгыг танилцуулъя. Үүнд, Оршилд асуудлын тусалт, сэдвийн судлагдсан байдал ба уг номын бүтцийг тодорхойлжээ.

Нэгдүгээр бүлэгт, Монголын тусгаар тогтнох гэсэн гол учир шалтгаан Петербургт илгээсэн монголын төлөөлөгчдийн үйл ажиллагаа болон оросын хандлага, мөн тусгаар тогтнолын тунхагийн дараах монголын байдлын нягтлан судалжээ.

Хоёрдугаар бүлэгт, Шинэ засгийн газар байгуулагдсаны дараа 1912 оны 7 сард шинээр байгуулсан Бүгд ерөнхийлөн захирах яамны тухай өгүүлжээ. Тэр дундаа Ерөнхий сайдын албан тушаалын эргэн тойронд, яагаад энэ үед шинээр зохион байгуулж буй, мөн яаманд яагаад Сайн ноён хан

Намнансүрэнг албан тушаалд томилсон бэ? гэдгийг тухайн үеийн Богд хаант засгийн газрын гадаад дотоод байдал, ялангуяа засгийн газрын доторхи Ван, гүнгүүд ба лам нарын хоорондын зөрчилдөөн болон Оросын оролцоо, мөн түүний цаана нь байгаа Орос Хятадын харилцаа, Япон Оросын харилцааг задлан шинжилжээ.

Гуравдугаар бүлэгт, Богд хаант засгийн газар нь 1912 оны 11 сарын 3 нд Оростой байгуулсан анхны олон улсын гэрээ болох “Орос монголын найрамдлын гэрээ”-ний тухай Оросын талын хэлэлцээрийн бодлого болон Монголын талын хандлагыг нягталсан нь, цаашид хэлэлцээрийн тохироо хэмжээнд “Монгол” гэдэг хэрэглэх болсон далд учир болгож, Орос Монгол хоёр тал ямар ямар санаа агуулж байсан бэ? Гэдгийг нарийн тодорхой шинжилжээ. Тус бүлгийг бичихэд Оросын бүрэн эрхэт төлөөлөгчийн хувиар энэхүү гэрээг байгуулсан И.Я.Коростовецийн тэмдэглэлийг чухалчилан ашигласан билээ.

Дөрөвдүгээр бүлэгт, “Орос-Монголын найрамдлын гэрээ” байгуулагдсаны дараа Петербургт илгээгдсэн Гадаад явдлын яамны сайд Ханддорж нарыг албан ёсны төлөөлөгчид хэмээн хүлээн авсан ба Петербургт явагдсан хэлэлцээр нь Хүрээнд болсон Орос Монголын хэлэлцээрийн үргэлжлэл гэсэн хэмжээнд авч үзжээ. Ялангуяа Өвөрмонголын асуудал, зэр зэвсэг, цэргийн сургагчийн тусламжийн асуудалд анхаарлаа хандуулж, Хүрээнд болсон хэлэлцээрээс Оросын тал эрс өөр байр сууринаас хандсаны учир шалтгааныг тодорхойлжээ. Энэхүү бүлэгт голдуу Монголд ардчилал болсон дээр зууны 90-ээд оноос хойш нээгдсэн Монгол улсын үндэстний төв архивт хадгалагдаж байгаа төлөөлөгчид үйлдсэн тэмдэглэлүүдийг түлхүү ашиглажээ.

Тавдугаар бүлэгт, Монгол улсын Үндэстний номын санд хадгалагдаж байгаа “Түмэн улсын ердийн цааз” бол уг бичгийн хятад орчуулга “wan guo gong fa” (万国公法 –ын Монгол орчуулга гэдгийг тодорхойлж, Богд хаант засгийн газар нь олон улсын эрх зүйг ашиглаж гадаад харилцааг судалж, олон улсын ердийн цаазад хэрэглэсэн үгийг гэрээний үгэнд ашигласан тухай бодитойгоор нягталсан байна.

Зургаадугаар бүлэгт, урьдын хүмүүсийн судалгаанд зөвхөн Богд хаант засгийн газарт дагаар орсон хошуудын тоог л чухалчлан үзэж байсанд чиглүүлэн нэг чуулганы арван хошуу бүгдээрээ дагаар ороход идэвхтэй хандаж ирсэн Шилийн голын чуулганаар жишээлж, дагаар орохоо илэрхийлэх үеийн ахуй бодит байдалд гол анхаарлаа хандуулжээ.

Долоодугаар бүлэгт, Мал аж ахуй голлон эрхэлж байсан Шилийн голын чуулгануудтай харьцуулбал, Хятадууд орж ирснээр улс төр, эдийн засгийн харилцаа төвөгтэй болж ирсэн Зуу-Удын чуулганы жишээнд Монголын тусгаар тогтнолд хандахад нь тус тус ямар зөрөө гарсан бэ? гэдгийг засаг ноёдын байдлаас голлон тайлбарлажээ.

Наймдугаар бүлэгт, Монголын тусгаар тогтнолд оролцох уу? үгүй юу гэдэг ашиг үгүй байдалд байсан Өвөр Монголыг бичсэн биш, Мөн эсвэл Хятад дахь Монгол үндэстний түүхийн хувиар бичигдэж байгаачлан биеэ даан тусгаар оршдог Өвөр Монгол гэсэн ч биш, харин өвөр Монголын хувьд Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн гэдэг нь чухам юу байсан бэ? гэдгийг Их-Зуугийн чуулганы жишээн дээр судалж үзжээ.

Ёсдүгээр бүлэг болон Аравдугаар бүлэгт, Тухайн үеийн Өвөр Монголд холбогдох судалгааг хошуудын дотоод байдалд хүртэл гүнзгийрүүлж, Зуу-Удын чуулган хэмжээнд хоёр засаг ноён зэрэгцэн гарсан байдлуудыг илэрхийлэн дэлгэж, хошуудын доторхи сөргөлдөөн болон тухайн хоёр хошууг хамаарсан улс төрийн байдлыг судалжээ.

Арваннэгдүгээр бүлэгт, Дээрх хоёр бүлгийн судалгаанд үндэслэн, улмаар тухайн үеийн Японы шинжилгээний бодитой материал зэргийг ашиглан, цагаагчин гахай жилийн хувьсгалын дараа уулын засаг ноёноос гадна өөр ван, гүн засаг ноёдод томилогдсон түүхт ахуйг хайн сүвэгчлэхийн дагуу өвөр Монголын нийгмийн бүтцийг задлан шинжилжээ.

Арванхоёрдугаар бүлэгт, Монголын улс төрийн байр суурийн эргэн тойронд нөхцөлдүүлэн, Орос Хятад хоёр улс Монголыг хэрхэн Хятадын сюзеренитет буюу эзэн мэдэх эрхийг хүлээлгэн буулгасан ба богд хаант засгийн газар хэрхэн автономит гэдэг хэлбэр дээр тохиролцсон тухай, Орос Хятадын тунхагийг Богд хаант засгийн газар хэрхэн тайлбарлаж байсан бэ? гэдэг асуудлуудыг Орос Хятадын тунхаг гарахаас өмнө Петербурgt илгээсэн Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчдийн үйл ажиллагааг хамааруулан шинжилжээ. Энэхүү бүлэгт Орос Хятадын тунхагт заасан сюзеренитет болон автономит нь Оросын талаас Монголын талд хэрхэн тайлбарлаж байсан бэ? гэдэг нь чухал юм. Тус бүлэгт Монгол улсын гадаад харилцааны архивт байгаа Оросын гадаад харилцааны архивын Орос хэл дээрх түүхийн материалыг Монгол улсын үндэстний төв архивт хадгалагдаж байгаа Монгол хэл дээр материалтай хамт ашигласан юм.

Арвангуравдугаар бүлэгт, Хиагтын гэрээ байгуулагдсан явцыг урьдчилсан судалгааны үндсэн дээр цэгцэлж, гэрээ байгуулагдсаны дараа гадаад Монголд үлдсэн өвөр Монголчууд болон бусад дагаар орогсдын үйл ажиллагаанд анхаарал хандуулж, Богд хаант засгийн газар тэдэнд хэрхэн хандаж байсныг судалж, тэд нарын цаашдийн хувь заяаг тодорхойлжээ.

Арвандөрөвдүгээр бүлэгт, 1921 онд Монгол улс хэрэг дээрээ тусгаар тогтнолоо олсон тухай, тодруулбал Монголын хувьсгалын талаар өгүүлжээ. Социализмийн үеийн БНМАУ-д “Монголын ардын хувьсгал” гэгч хамаг хүчээ тавьсан судалгааны сэдэв байсан байжээ. Тэр нь дарангуйлан захирагч монополь эрх бүхий улс төрийн нам МАХН-аас өөрийн засгийн эрхийг барих явдлаа зөвтгөн номчлохын төлөө Монголын ардын хувьсгалыг

баримт болгон ухуулж байжээ. Дээр зууны сүүлчээр болсон ардчилалын үеэс эхлэн “түүхийг дахин засварлах” хэмээсэн Монгол ардын хувьсгалын тухайд бол хэлмэгдсэн хүмүүсийн нэр төрийг сэргээх ба дахин үнэлгээ өгөх, тухайн үнэн хэргийг шинээр илэрхийлэх зэрэг байдал харагдаж байгаа боловч түүнд томоохон асуудал бугшиж байна гэж бодогдоно. Тиймээс 1921 оны 2 сарын 22 ны өдөр дахин сэргэсэн Богд хаант засгийн газарт анхаарал тавихаар дамжиж, энэхүү “түүхийг дахин засварлах” оролдлого хийжээ.

Дүгнэлтэнд 1911-1921 он хүртэлх Богд хаант засгийн газрын тухай үйл явдлуудыг нийлүүлэн авцалдуулж Монголын түүхэн дэхь энэхүү засгийн газрын байр суурийг илүү тодорхойлж, цаашид ажиглан харах асуудлуудыг дурьджээ.

Дээрхээс үзэхэд, тус номын бүхий л агуулга нь үндсэндээ гурван их хэсэгт хуваагдаж байна.

Тэргүүн хэсэгт “Богд хаант засгийн газрын байгуулагдсан ба тусгаар тогтнолын хүсэл эрмэлзэл” хэмээх найрлагаар, монголчууд тусгаар тогтнолоо зарлан тунхагласны өмнө хойнох үед тулгарсан гадаад харилцааны холбогдох асуудлуудыг нягтлан судалсан буй? Энэ нь Богд хаант засгийн газар нь хэрхэн буй болсон ба оршин тогтнож чадсан, эцэстээ үнэнхүү тусгаар тогтнолыг хэрхэн олсон гэдэг тус судалгааны үндсэн агуулгад хамаарагдах асуудлууд юм. Эдгээр асуудлыг судлахад хаант Оросын оролцоо хамаг чухал болж ирэх учраас энд голдуу “Империалист үеийн олон улсын харилцаа”, “монголын асуудалд холбогдох гадаад харилцааны архивын эмхтгэл” зэрэг Орос хэлний бичиг баримт болон “В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг” зэрэг ховор нандин материалыг дэлгэрэнгүй ашиглаж чаджээ.

Дэд хэсэг нь “Богд хаант засгийн газар болон өвөр Монгол” хэмээх найрлагаар, Богд хаант засгийн газар болон өвөр Монголын хоорондох харилцаа холбоог ашигласан байна. Дээр зууны 90-ээд оны эхээр үүссэн ардчилсан хувьсгалын дараа Монгол улсад шинэ түүхийн үзэл бий болжээ. Ийнхүү түүх судлалын шинэ урсгал дунд, урьд урьдын зөвлөлт Оросын улс төрийн дарамт хавчлагаас чөлөөлөгдөж, жинхэнэ эрх чөлөөгөө олж авсан Монголчуудын хувьд “Монгол улсын түүх”-ийг бичих явдал нь тулгамдсан их үүрэг болсон байна. Ингэхэд хүмүүс тухайн түүхэн цаг үеийн улс төрийн байдал хийгээд хил хязгаар нь тодорхой үгүй байсныг “улсын түүх” хэмээх өнөөдрийн төр улсын нэгжээр тодорхойлох хэмээн оролдож байна. Гэвч энэхүү тохиолдолд өнөө “улсын түүхийн ар сүүдэрт зарим чухал асуудал халхлагдан бүрхэгдэх буюу хаягдаж гээгдэх юм. Түүний нэг нь тухайн үеийн өвөр Монголтой үүсгэсэн харилцаа холбоо болно.

Тус хэсэгт голдуу урьдын судлаачдын ер нь ашиглаж үзээгүй нилээд олон шинэ материалыг ашигласан байна. Тухайлбал Монгол улсын Үндэстний төв

архивт хадгалагдаж байсан Богд хаант засгийн газар болон өвөр Монголын засаг ноёд, тайж нарын хооронд нааш цааш явуулсан их хэмжээний бичиг баримтуудыг ашигласан нь уншигчид судлаачдын анхаарлыг зүй ёсоор татна.

Сүүлчийн хэсэг нь “автономитоос тусгаар тогтнол тийш” хэмээх тусгаар тогтнол тунхаглагдсаны дараах Монголын улс төрийн байр суурийг мөрдөн судалжээ. 1913 оны 11 сарын 5 ны өдөр байгуулагдсан “Орос Хятадын тунхаг”, 1915 оны 6 сарын 7-нд батлагдсан “Хиагтын гэрээ” 1919 оны 11 сарын 22 ны өдөр автономитыг хүчингүй болгож 1921 оны 2 сарын 22 ны өдөр, автономитийг дахин сэргээх мөн оны 7 сарын 10 ны өдөр Ардын засгийн газар байгуулагдсан зэрэг түүхийн бодит хэрэг явдлуудыг авч үзсэн байна. Мөн энэхүү түүхэн явцаар Богд хаант засгийн газар нь “тусгаар тогтнол”-оос “автономит”, “автономит”, “автономитийг цуцлах”, “автономитийг дахин сэргээх”, “тусгаар тогтнох” гэх мэтийн янз бүрийн муруй саруй бэрхшээлт замыг туулсан ул мөрийг сүвэгчлэн тодорхойлжээ.

2. Зохиолын ач холбогдол

Дээр дурьдсан тэдгээр агуулгууд нь судлагчдын хувьд ч гэсэн XX зууны Монголын түүхийг анхааран сонирхдог энгийн уншигчдын хувьд ч гэсэн авч ярих юм бол үнэхээр их татах хүчинтэй шинэ сэргэг зүйлс байгаа гэдгийг эргэлзээгүй хэлж болно.

Цаашид тус номын ач холбогдол буюу анхаарал татахуйц зүйлүүдийг шүүмжлэгчийн ойлголтын хэр хэмжээний хэвчээнд тоочин өгүүлж, сацууд нь өөрийн сэтгэгдлээ олонтойгоо хуваалцахыг хичээв.

Нэгдүгээрт, тус номын хамгийн том ач холбогдол бол XX зууны Зүүн Азийн түүхэндэх Монголын түүхийг дүрслэн харуулсан явдал болно. Өөрөөр хэлбэл, ямар нэг их гүрний сүүдэр доорхи цөөнх этгээдийн түүх гэж үзсэн биш, мөн ч нэг хэсгийг л баримталсан “Улсын түүх” хэмээх хэвшилд тохсон биш, харин Монголын орчин үеийн түүхийг Зүүн Азийн түүхэнд байр суурьтай авч үзсэн явдал болно. Зохиогчийн өөрийнх нь хэлсэнчлэн, 1911 онд тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаас хойш түр зуурын зогсонгуй байдалд орсон удаа байсан ч, 1921 оны Ардын засгийн газар байгуулагдах хүртэл үргэлжилсэн Богд Хаант засгийн газрын үйл ажиллагааны талаар судлан, түүнд тайлбар өгөхийг оролдсон бөгөөд “Монгол улсын түүх” ч биш, Хятадын доторхи “Монгол үндэсний түүх” ч биш үнэнхүү” Монголын түүх” бичихийг зорьсон байна¹.

Монголчууд яагаад тусгаар тогтнолын хөдөлгөөнийг өрнүүлсэн бэ? гэдэг нь тус судалгааны асуудлын гогцоо мөн. Битүү мушгирсан үйл

1. Тачибана Макото “Богд Хаант засгийн газрын тухай судлал-Монгол Улсын байгуулагдсан түүх (1911-1921)”, Казамаи шиебү (Токио), 2011 он. т.463.

явдлын зангилгын талаар судалгаа өрнөж, өнгөрсний судлагчдын дунд өргөн яригдаж ирсэн бөгөөд Монголчуудыг тусгаар тогтнол уруу оруулсан шалтгаан нь Монгол оронд “Шинэ засгийн бодлого” нэвтэрснээс болжээ гэсэн дээр санал нэгдэж буй. Гэвч зохиогч бээр” Энэ шинэ засгийн бодлогыг хэрэгжүүлэхээс өмнө Жавзандамба хутагт Петербургт элчээ илгээсэн гэсэн мэдээ хэд хэдэн бичиг баримтад тэмдэглээстэй байна” гэжээ. Энэ тухай 1900 онд Да лам Бадмаадорж, зайсан Цэрэн-Одзор нарыг их Оросын газар тусгай захидал бариулан илгээсэн ба 1895 онд Цагаан Хаанд элч томилон Монголчууд Манжаас салж тусгаар тогтносон улс болох явдалд Оросоос тусламж гуйсан тухай баримтууд гэрчилж байгаа юм². Зохиогч бодитой асуудлын шинэвтэр сэргэг зүйлийг илрүүлж чадсан мөртөө тухайн түүхийн үнэнхүү шинж төлөвийг гаргаж чаджээ. Бусад эрдэмтэдийн зохиолд харагддаг “Ийм нэг шалтгаан байснаас л тийм дүн гарсан” гэх мэтчилэн ээдрээн будлиантай түүхийг дөхөмчилөн томьёолох буюу ямар нэгэн загварт тохож сэтгэдэг нь шинжлэх ухаанч биш. Түүхийн үнэнтэй ч нийцэхгүй юм. Өөрөөр хэлбэл, 1911 оны Монголчуудын эрх чөлөөний хөдөлгөөн үүссэн үндэс шалтгаан нь охорхон хугацаанд болсон гэвэл арай дөхөм томьёолол болж мэднэ. Үнэндээ Чин гүрний сүүлч үеийн нэлээд урт хугацааны турш Монголчуудын тэмцлийн хөгжлийн гараа, эрч зориг яваандаа чангарч ирсэн гэж таних хэрэгтэй. Иймээс 1900 оны өмнө хойнох үеэр монголчуудын дунд тусгаар тогтнох гэсэн зориг санаа хөвөрч байсан гэдэг боловч энэ нь “Шинэ засгийн бодлогыг” хэрэгжүүлэх явдлаас үүсэлтэй гэдэгт зохиогч эргэлзэж байгаа нь ойлгомжтой юм.

Хоёрдугаарт, Оросын оролцооны тухай. “Богд Хаант засгийн газрын тухай судлал”-ын бас нэгэн хамгийн үнэ цэнэтэй хэсэг нь 1911 оноос 1921 он хүртэлх Монголын түүхэн дэх Оросын хүчин зүйл буюу Оросын оролцоог онож тодорхойлсон явдал болно. Уг асуудлын тухай өмнө нь эрдэмтэд өөр өөрөөр тайлбар хийсээр иржээ. Монголын түүхчид Оросын оролцоог ямар нэгэн хэмжээнд ярьдаг боловч төдий их идэвхитэй үнэлдэггүй. Энэ тухай бодитой судалгаа ч төдий гүнзгийрээгүй юм. Тэгвэл зарим том гүрний түүхчдийн баримталдаг нь юу вэ? гэвэл Монголын тусгаар тогтнол гэдэг нь хэрэг дээрээ цаана нь Хаант Оросын өдөөн хатгалгаар бий болсон бөгөөд тэр нь зөвхөн Их хүрээ зэрэг хэсэг хэвчээнээ үүссэн цөөн тооны ван гүн лам нарын үйлдсэн хэрэг байжээ гэж үздэг. Хүмүүс мөн ер нь тийм байсан байх хэмээн том түүхчдийн үгийг итгээд уг үйл явдлыг нарийвчлан ойшоож үзсэнгүй. Гэвч одоо “Богд Хаант засгийн газрын тухай судлалыг” нарийн уншихад нээрэн авч үзүүштэй зүйлүүд тодорхой харагдаж байна. Юуны өмнө, Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн нь ямар нэгэн өөр хүчний түлхээс буюу өдөөлгөөс болсон биш, өөрсдөө хүсээгүй үйл явдал огт биш, харин нийт монголчууд хамтаараа хүсээд Манж Чин улсаас салж

2. Мөн дээрх, т.36-37.

тусгаар улсаа байгуулья гэсэн түүхт хүсэл эрмэлзлэлийн нь үр дүн байсан учраас түүхийн эдгээр бодитой байдлыг Монголын нийгмийн дотоод хүчин зүйлээс шууд ургаж гарсан үнэн бодитой учир шалтгаантай үйл явдал гэж үзэхгүй байхын аргагүй. Түүнээс өөр хэн нэг нь гаднаас чихэж оруулсан юм биш. Гэхдээ, бид бас нэг зүйлийг харж үзэх шаардлагатай гэдгийг доктор Тачибанагийн судалгаанаас ухаарч болох мэт. Тухайлбал, Монголын цагаагчин гахай жилийн хувьсгал нь хэдийгээр Монголчуудын өөрсдийнх нь шалтгаан нөхцөл байгаад сая гарсан хэрэг гэдэг боловч бас түүнийг нөлөөлсөн хүчин зүйлийн асуудлыг сэтгэж үзэх хэрэгтэй. Олны мэдэхээр, орчин үеийн Монголын асуудалд ер нь өмнөд хөрш болон хойд хөршөөс болсон хүчин зүйлийн нөлөө аргагүй асар их байсан юм. Юун түрүүнд Хаант Оросын зүгээс Монголд явуулсан бодлого, үйл ажиллагаа нь Монголын нийгмийг ихээр нөлөөлж байжээ. Уг нь Монголын түүхчид энэ талаар анхаарал тавьдаггүйн чухал нэг шалтгаан нь, хэрэв Оросын оролцоо энэ тэр гээд яриад байвал дотоодын хүчин зүйлийг бууруулахад хүргэж үндэсний түүхийн үзэл хандлаганд харш болох юу магад гэж үзэж байсантай холбоотой байна. Эдгээр омтгойлогдсон буюу мартагдсан түүхийн үйл явдлуудыг ул мөртэй нарийвчлан судалсан “Богд Хаант засгийн газрын тухай судлал” номоос бид Монгол улс байгуулагдах түүхийн үйл явдалд Хаант Оросын нөлөө хэдий их байсан гэдгийг тодорхой олж харж болно.

Энэ үеийн түүх төдийгүй, дараа дараагийн үйл явдалд бүр Оросын хүчин зүйл нөхцөлдөх болсон юм. Өөрөөр хэлбэл, XIX зууны сүүлчээс эхэлж ийм нэг том хүчин зүйлийн байнгын нөлөө XX зууны Монголын түүхэнд тодорхой тусгагдсан байна. Тухайлбал, 1912 оны Орос, Монголын найрамдлын гэрээ, 1913 оны Өвөр монголын асуудал, мөн оны Бээжингийн хэлэлцээр Орос-Хятадын тунхаг, 1914 оны гурван этгээдийн Хиагтын хэлэлцээр гэх мэт. Эдгээрийн цаана нь бүр Оросын найруулсан бодлого шингэж байжээ.

Гуравдугаарт, Өвөр Монголын асуудал. Богд Хаант засгийн газар болон Өвөр монголын хоорондох харьцаа холбоо буюу Өвөр Монголын асуудлаар голлосон судалгааг авч үзэхэд, энэ талын агуулга нь бүх номын хагасаас давуу хуудсанаа дэлгэрэнгүй бичигдэж байна. Тусгай Өвөр Монголын тухай нарийн бодитой шинжлэн судалсан нь мөн ч тус номын гол сэдвийн нэг болж урьдчилсан судалгаанд ер харагдаагүй эрдэм шинжилгээний томоохон бүтээл болсныг онцлон тэмдэглэх ёстой. Яриангүй энэ талаар хийгдсэн чухал судалгааг цэгцэлбэл, Юуны өмнө Наками Тацүогийн “Хайсан ба Удай: Богд Хаант засгийн газар дахь Өвөр Монголчууд”³, Л.Жамсран “Монголчуудын сэргэн мандалтын эхэн”, УБ., 1992 он болон Өргөдэй Тайвангийн “Богд Хаант засгийн газар болон Өвөр Монголын улс төр”⁴-ийг дурьдахгүй

3. Наками Тацүо “Хайсан ба Удай: Богд Хаант засгийн газар дахь Өвөр монголчууд”, Тооёо Гакүхо (Токио), 57 боть, №1-2, 1976 он. Тус өгүүллийн хятад орчуулга нь Өвөр монголын их сургуулийн Орчин одоо үеийн түүх судлах газрын найруулсан “Өвөр монголын орчин үеийн түүхийн орчуулгын цуврал”, гуравдугаар товхимол, 1991 онд нийтлэгджээ.

4. Өргөдэй Тайван “Богд Хаант засгийн газар хийгээд Өвөр монголын улс төр”, Осака

байж болохгүй. Л.Жамсран, Т.Наками, Тайван нар энэ талын ажлыг үүсгэн хийсэн боловч, улам нэг алхам гүнзгийрүүлэн судалсан мөртөө нэн олон бодит жишээн дээр олон арвин асуудлыг тодруулан бичсэнээрээ Тачибанын бүтээл бусдаас тусгайран онцгой байр суурь дээр тавигдах болно. Энэ нь мөн Өвөр Монголын асуудлын талаархи судалгаа цаашид улам хүчтэй болох нөхцөлийг бүрэлдүүлж өгсөн байна.

Зохиогч яагаад судалгаандаа Өвөр Монголын талыг эрхэмлэн үзсэн бэ гэвэл, түүхийн баримт материалд тулгуурлан бодит үнэнд шудрага хандсан залуу түүхчинд түүхийг шинээр засварлаж бичих шаардлага тавигдсан гэлтэй. Үнэн хэрэг дээрээ Өвөр Монголын асуудал нь Монголын тусгаар тогтнолтой адилхан чухал асуудал болох ёстой мөртөө Монгол улсын нутаг дэвсгэрийг шийдвэрлэх асуудалтай ч шууд холбоотой байсан боловч өнөөдрийн ноёлогч “Улсын түүх”-ийн ар сүүдэрт дарагдсаар иржээ. Өвөр Монголын хувьд тэр үеэс эдэрээт бэрхшээлт байдалд оршин Богд Хаант засгийн газар болон Иргэн Улсын засгийн газарт давхар хавчигдаж, тухайн бүс нутаг уруу бас Япон нэвтрэн орох оролдлого явуулж байсан нэн нарийн түвэгтэй байдалтай байжээ⁵. Өнөөгийн ар, өвөр Монголын хагарсан шалтгааныг өгүүлэн бүхий тэр үетэй холбон үзэх ёстой. Энэ талаар судлагчид өөр өөрөөр тайлбарлаж байна. Гэвч аль аль нь ч бодит байдалтай нийцэхгүй. Өөр өөрийн биеч зорилтоороо тайлбарлаж байна. Энэ талаар зохиогч бодит байдлыг тодорхой болгох бүтээлч оролдлого хийж, Монголын тусгаар тогтнол тунхаглагдсаны дараахь Өвөр Монголын хандлагыг тодорхойлохдоо Шилийн гол, Зуу-уд, Ихзуу, Жирэм зэрэг нэлээд өргөн бүс нутгийн хэмжээнд жишээ авч шинэ хэрэглэгдэхүүнд түшиглэн нэг нэгээр шийдвэрлэжээ.

Дөрөвдүгээрт, Их зуугийн чуулганы жишээ. Их хүрээнд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөн мандаж байгаа үед, Өвөр Монголын зүүн бүсийн олон хошуу чуулган нь Ар Монгол зүг хандаж Богд Хаант засгийн газрыг дагах зорилгоор бослого буюу үйл ажиллагаануудыг их, бага аль нэг хэмжээгээр үүсгэж байжээ. Гэтэл Их зуугийн чуулган мэтийн баруун чуулганы хошуудын байдал арай өөр юм⁶. 1911 оны 12 сарын 7-ны өдөр Ар Монголын засгийн газраас Шилийн гол, Улаанцав, Их зуугийн чуулган зэрэг чуулганы дарга нарт хандан нэгдэн нийлэхийг уриалсан бичгийг гаргаж яаравчлан ирүүлсэн байжээ. Үүний улмаас, Их зуугийн чуулганы дарга Арвинбаяр чуулган доторхи бүх хошуудын засаг ноёдыг цуглуулан хуралдсаны үр дүнд 13 зүйлийн асуулт тавьсан бичиг бичиж Хүрээнд илгээжээ.

Гадаад судлалын их сургуулийн эрдэм шинжилгээний нийгэмлэг, Докторын өгүүллийн цуврал, Осака, VOL.19, 2003 он.

5.Зүүлт 1, т.464-465.

6. Д.Өсөхбаяр: “Богд Хаант засгийн газар болон Өвөр монголын Их зуугийн чуулганы хоорондын харьцааг судлах нь”, Өвөр Монголын их сургуулийн магистрийн зэрэг хамгаалсан өгүүлэл, 2012 он.

Дараа нь Богд Хаант засгийн газраас Их зуугийн чуулганы ноёдын 13 зүйлийн асуултын хариу бичиг илгээж асуултанд зүйл дараалан тодорхой хариулт өгчээ.

Зохиогчийн шинээр олсон эдгээр бичгүүд бол тухайн үеийн үйл явдалтай шууд холбогдох бодит баримт мөн. Эдгээр эх сурвалжийн баримт бичгүүдийг ахмад эрдэмтэд нэг их анхаарч чадсангүй бололтой. "Богд Хаант засгийн газрын тухай судлал"-д тухайн үеийн Их зуугийн чуулганы эргэн тойронд болсон эдгэрэн будлиантай үйл явдлуудыг маш тодорхой онож тайлбарласан юм. Нарийвчилбал, Монгол тусгаар тогтнолыг зарлан тунхагласан ба Их зуугийн чуулганы засаг нарын дагаар орох асуудал яригдаж байгаа үед тус чуулганы хошуудын доторхи сөргөлдөөн хурцдан, мөн Хятадын талаас болсон аймшигт орчноос Чингисийн туг сүлд, найман цагаан ордыг хэрхэн хамгаалах тухай асуудал тулгарч, дээр нь бас баруун чуулганы ван гүн нарын хурал болж байдал улмаар ширүүсэж байжээ. Ширүүн будлиантай үйл явдлын бодитой үнэнийг тодруулахад нэн олон эх сурвалжийн бичиг баримтыг аль чадахуйц арвин олох хэрэгтэй. Эдүгээ зохиогчийн ашигласан баримт материалаас өөр бас нэгэн баримт харагджээ. Зохиогч болон уншигчдын лавлахад зориулж энд танилцуулъя. Энэ нь Их зуугийн чуулганы засаг ноёд 13 асуулт бүхий бичгийн хамт Их хүрээнд хүргэсэн бичиг хэмээгдэж буй. Түүний агуулгыг сийрүүлбэл доорх мэт.

"Халхын хүрээний газрын бүгд хэргийг ерөнхийлөн захиран шийтгэх да түшээ гүн Чагдаржав, хамаарсан да жүн ван Гомбосүрэн, ээвлөн шийтгэх хамаарсан жанжин хэбэй бэйс Гомбосүрэн, ван Цэдэнсоном, гүн Намсрай, да лам Цэрэнчимэд нар танаа хойш илгээв. Явуулахын учир, эдүүгээ эрхмүүдийн газраас хүрч ирсэн бичгийн товчид эрхэм Шилийн гол, Улаанцав, Их зуугийн чуулганы дарга нар, Алашаа ванд довтолгон явуулаад хүрмэгц хянан үзэж уламжлан харьяат захирах олон хошуудад зарлан тушааж өөр өөрийн нутгийн сүв боомт зэрэг газарт хурдан түргэнээр анги хуваан цэрэг томилон суулгаж сэрж сэргийлүүлэн, муу дүрсгүй харгис иргэд явахуй нь буй бөгөөс инагш нэвтрүүлэн одуулахгүй болгон үлдэн хөөж, нэгэнтэйгүүр манай газар хурдан түргэнээр мэдүүлэн ирүүлээд газар орныг ариун чанга болгосугай. Үүнийг басхүү дөрвөн аймгийн чуулганы дарга, туслагч жанжин нар, Хиагтын хоёр этгээд харуулыг захирах бэйс гүн нарт тус тус явуулан тушаагаад хүрмэгц өөр өөрийн харьяат газар уламжлан тушааж нэгэн адил шийтгүүлсүгэй хэмээн хүрч иржүхүй. Үүнд манай Их зуугийн чуулганы дарга, дэд дарга, шийтгэгч дарга нар ба олон засаг түшмэд бүгдээр цуглаж хянан зөвлөлдбээс, манай аймгийн нутагт болбасу хэдийнээс дотоодын иргэд хэрэм гарч арилжаа тариалангаар хоргодож суусаар олширсанд нутгийн Монголчууд аливаад уудамгүй бөгөөд тэдний харгис номхоньг ялгаж танихуйя бэрх болжухуй. Нэн ялангуяа манай Ордос аймгийн нутгийн дотор Монгол бүгдийн шүтэн хичээнгүйлэх эртний

Чингис богд эзний шарил шүтээн ба тэнгэрийн шүтээн хар сүлдийн гэгээн таныг оршуулан тахиж буй бүхийн дээр, нийт хийд сүм ч хэдэн зуу илүү оршин бүхий энэ зүйлийн нутагт одоо өмнө зүгийн иргэд санаа хувьсаж олон бүлэг бүлэглэж бидний зах хязгаарт ойртоор ирж байн байн олныг цочоон үймүүлэх нь маш түгшүүртэй буй явдлыг мэдэгдэхээс гадна, манай хэдхэн хошуу язгуураас цэрэг зэвсэг маш цөөн буурай тул, ихийг хамгаалан чадах байтугай нутаг орноо ч сахин хамгаалах бэрхшээлтэй бүхий үнэн учрыг хамтаар гарган хойш яаравчлан явуулсугай, хүрхүл Хүрээний газрын бүгд хэргийг шийтгэх газараа тольчин шийтгэх ажааму. Үүний тул хойш илгээв. Хар хулгана жилийн хаврын дунд сарын арван тавнаа энэ бичгийг суудлын бошго Ардарт тушаав⁷.

Тавдугаарт, "Хувьсгалын түүх"-ээс хэлтрэх боломж. "Богд Хаант засгийн газрын тухай судлал"-д нэг шинэ түүхийн танилтыг буй болгожээ. Үүний улмаас сая түүх засаж бичигдэх боломж буй болсон гэж танивал зохистой билээ. Энэ нь орчин одоо үеийн Монголын түүхийг таних хэвшлийн өөрчлөлтийн асуудалд холбогдох бөгөөд тус номын эрдэм шинжилгээний аугаа их ач холбогдол нь мөн үүн дээр оршино.

Богд Хаант засгийн газрын Монгол улсын тусгаар тогтнолоо олоход хүнд үүрэг гүйцэтгэсэн гэснийг хэн ч үгүйсгэх арга байхгүй. Гэтэл одоод тултал тус засгийн газар нь 1919 онд автономит эрхээ устгагдаж түүхийн тавцнаас буусан хэмээгдэж, харин Монгол улс тусгаар тогтнолоо олсон бүх гавьяаг Монгол Ардын Хувьсгалт Намд оноож тайлбарлаж ирсэн билээ. Тийм учраас Богд Хаант засгийн газар болон Ардын засгийн газрын хоорондох харьцаа бүрмөсөн баллагдаж, Монголын хувьсгалд Богд Хаант засгийн газрын гүйцэтгэсэн үүргийг ярьдаггүй болжээ. Гэхдээ энэ мэт 1921 оны Монголын хувьсгалыг түүнээс өмнөх түүхнээс нь ангид салгаж судлуулах явдал нь социализмын үед зохиогдсон "Хувьсгалын түүх"-ийн шаардлагаас болсон юм. Үүгээр Монголын тусгаар тогтнол биелэгдсэний бүх гавьяаг Монгол Ардын Хувьсгалт Намд ноогдуулах хэмжээнд хүргэж, энэ үндсэн дээр Монгол Ардын Хувьсгалт Намын ноёрхлыг зөвтгөсөөр ирсэн юм. Өөрөөр хэлбэл, Богд Хаант засгийн газар нь 1919 онд дуусжээ гэж үздэг судалгаанууд нь үнэндээ өөрийн ноёрхлоо зөвтгөн номлох гэсэн Монгол Ардын Хувьсгалт Намын жолоодлого дор явагдаж ирсэн түүхийн судалгааг тэр хэвээр нь үргэлжлүүлж байгаа хэрэг юм. Гэвч түүх бол түүхээр л байх ёстой. Богд Хаант засгийн газар 1911 онд үүсэн мандсанаас хойш 1921 онд Ардын засгийн газар байгуулагдах хүртэлх явц дундаа хэсэг үе тасалдсан ч гэсэн эцэстээ үргэлжилсээр байсан гэдэг бол хөдөлбөргүй үнэн юм. Яг ингэж Богд Хаант засгийн газар үүсэн мэндэлж оршин тогтнож байсан учраас сая 1911 оны тусгаар тогтнолын тунхаг, нэн өргөн хэвчээний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон 1921 оны хувьсгал үргэлжлэн гарч чадсан

7. Зүүлт 1, т.27-28.

юм. Иймээс Монгол улс байгуулагдахын үндэс суурь нь даруй Богд Хаант засгийн газар мөн гэдгийг үгүйсгэх арга алга. Иймэрхүү түүхийн танилт баймаанжин сая социализмын цаг үед буй болсон "Хувьсгалын түүх"-нээс хэлтрэх нэгэн боломжыг олж чадах юм⁸.

Цаашид өгүүлэхэд, дээр баахан дэлгэрэнгүй ярьсан таван талын агуулгаас гадна, тус номд бас нэлээд олон шинэ оночтой зүйл харагдаж байна. Энэ тухай цухас тэмдэглэвэл :

-1912 оны 7 сард Бүгд ерөнхийлөн захирах яамныг байгуулж, ерөнхий сайдын албан тушаалд сайн ноён хан Намнансүрэнг томилсон явдал нь Богд Хаант засгийн газрын дотоодын сэргөлдөөн хийгээд Оросын оролцооноос болсон⁹ хэмээх шинэ үзэлтийг дэвшүүлжээ.

-Одоо Монгол улсын Үндэсний номын санд хуулбар байдлаар хадгалагдаж байгаа "Түмэн улсын ердийн цааз" хэмээх монгол орчуулгын судар нь уг судрын хятад орчуулгыг дамжиж гарсан бүтээл болох, өөрөөр хэлбэл уг бичгийн хятад орчуулгын монгол орчуулга мөн гэдгийг тодолж гаргасан бөгөөд цаашид Богд Хаант засгийн газар өөрийн үйл ажиллагаадаа олон улсын эрх зүйн толь бичиг болох Энэхүү "Түмэн улсын ердийн цааз"-ыг ашиглаж байсныг тодорхойлжээ¹⁰. Тухайн үед Хятад бичгээс орчуулах ажлыг голдуу өвөр Монголоос очсон хүмүүс гүйцэтгэж байсан бололтой. Одоо Монгол улсын Архивын газруудад нилээд тооны орчуулгын судар булагдаж байхыг судлагчид арай сайн ойшоож үзээгүй байна. Ялангуяа өвөр Монголын судлагчид анхаарлаа хандуулбал зохино.

-Зохиогч энэ номынхоо багагүй хэсгийг Өвөр Монголын тухай асуудалд зориулсан байна. Жарууд, Хишигтэн зэрэг хошуудад хоёр засаг зэрэгцэн оршиж байсан уг шалтгаан, Хошууны доторхи зөрчил мөргөлдөөнийг бодитой илрүүлж гаргасан нь уг судлалын хамаг чухал нэг амжилт болно.

-Зохиогч найман цагаан ордыг хойшоо шилжүүлэх асуудлыг нэн гүнзгийрүүлэн нягталснаа, Оонос Цогт¹¹, Өргөдөй Тайван¹² нарын судалгаад шүүмжлэлтэй хандаж, тухайн үеийн Их зуугийн чуулганы байдал маш түгшүүртэй байсан ч найман цагаан ордыг "Тусгаар тортносон Монгол улсын бэлэг тэмдэг" болгох гэж байсан хэмээн хэлэхэд бэрх юм гэж дээрх судлаачдад хандуулан болгоомжтой санал дурьдсан нь зүйтэй юм.

Давтан хэлэхэд, өмнө нэг түүхчээс "Дотоодын хямралдааны дээдсийн уламжлалтай монголчуудад авч хэлбэл аяндаа хуучин архагийг нь

8. Зүүлт 1, т. 467.

9. Зүүлт 1, т.69-76.

10. Зүүлт 1, т.155-162.

11. Оонос Цогт. "Чингис хаан тайлга: Түүхийн антропологийн шинэ цогцолборт хийсэн оролдлого", Фүкиюшия хэвлэлийн хороо (Токио), 2004 он, т.319.

12. Өргэдэй Тайван. "Үхэр жилийн үймээний гэрэл ба сүүдэр", Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2006 он., т.123.

хөдөлгөхөөс өөр юм болохгүй юм” гэж хэлжээ¹³ Зохиогч мөн тус номдоо Монголын ноёд язгууртад, улс төрчдийн хоорондох зөрчил мөргөлдөөн жич тасрашгүй дотоодын сөргөлдөөнийг ул мөртэй үндэс баримттай дүрслэн бичжээ. Үүгээр бид Монголын түүх буюу Монголчуудын хувь заяаг тайлах нэг түлхүүр болгож болох мэт санагдана.

3. Санал шүүмжлэл

Дашрамд шүүмжлэгчийн хувьд зарим эргэлзээтэй зүйл буюу зөвлөгөө авах чухалтай хэмээн санагдсан хэдэн асуудлыг дэвшүүлье.

Юуны өмнө, зохиогч Сан ламын тухай нарийлаг бичиж, түүнд холбогдох үйл явдлыг нэлээд тодорхой өгүүлээд “Үнэн хэрэг дээрээ Цагаагчин гахай жилийн хувьсгалын дараахь түүний үйл ажиллагаа нь Юань Шикайн нохой” гэж үзэх боломжтой байсан бөгөөд Харбинд очсон зорилго нь ч Хүрээнд очоод Ар Монголыг Дундад Иргэн Улсад дагаар оруулах явдал байсан байна¹⁴ хэмээн дүгнэсэн шинжтэй байна. Үүнийг цаашид нягтлууштай. Өгүүлэн бүхий цаг үед” Сан лам” хэмээх хоч буюу цолтой хоёр хүн байжээ. Нэг нь Амарцэнгэлт гэдэг, нөгөө нэг нь даруй тус номд яригдаж байгаа Сэдэнбалжуур болно. Үүнийг “XX зууны Монголын түүхийн эх сурвалж (1911-1921)”¹⁵ хэмээх эмхтгэл дотор “Сэдбалжуур” хэмээн буруу тэмдэглэжээ. “Сан лам” хэмээх энэ хоёр хүний тухай хялбархан хутгалдах тал олон буй. Гэхдээ, хоёр удаагийн Зүүн Монголын ван гүн нарын хуралд биеэрээ оролцсон бөгөөд Юань Шикайн өмнөөс Өвөр монголын хошуу чуулгануудыг Иргэн улсад дагуулах гэж зүтгэж байсан хүн бол Амарцэнгэлт болно. Зохиогчийн тэмдэглэж байгаа Богд Хаант засгийн газарт санамж бичгийг дэвшүүлсэн Сан лам Сэдэнбалжуур бол энгийн хүн лав биш, нээрээ “Юань Шикайн нохой”-н дүрийг тоглож байсан юм уу? Чухам Хүрээнд очоод юу хийсэн бэ Энэ асуудал одоогоор тодорхойгүй. Тус санамж бичгээс үзвэл, түүнийг аль талын хүн гэж дүгнэх асуудалд болгоомжтой хандвал зохино. Дээр дурьдсан “Эмхтгэл”-ийн уг эмхтгэгч Дэндэв бээр “1912 оны зун цаг дотоод монголын төлөөлөгч лам Сэдбалжуураас Монгол улсын тусгаар улс байгуулсан тухайн хэрэг ажилд эргэлзэн татгалзсан саналыг илтгэж мэдүүлсэн бичиг” гэж гарчигласан нь үнэндээ их оновчгүй юм. Уг бичгийг нарийн уншихад, Сэдэнбалжуур Монгол улсын тусгаар тогтнолыг эсэргүүцэж байгаа явдал биш. ”Шудрага үг чихэнд тааламжгүй боловч явдалд тустай, сайн эм аманд гашуун боловч өвчинд тустай” хэмээн цаанаа гүн нямбай утга бүхий үнэн бодитой асуудлыг дурьдсан байна. Яриаг товчилбол, юу ч гэсэн хоёр Сан ламын үйл ажиллагааг цаашид нарийн ялгаж

13. Мөн дээрх, т. 40.

14. Зүүлт 1, т. 319.

15. “XX зууны монгол түүхийн эх сурвалж (1911-1921)”, О.Батсайхан монгол үсгээс кирилл үсэгт буулгаж хэвлэлд бэлтгэв, УБ. 2003 он.

тунгаах чухалтай байна. Дагалдуулан ярих нэг зүйл гэвэл, Тянь Жихө, Фэн Шиожүн нарын номд¹⁶ Сан ламын тухай энд тэндгүй эндүү буруу бичиж буйг анхаарвал зохино.

Мөн “Таван замын цэрэг Өвөр Монголд орсон тухай зохиогч бээр цэргүүдийн томилогдох газар нутаг нь гол төлөв Халхын өмнө зах болон түүнтэй хил нийлсэн Шилийн голын чуулган ба Улаанцавын чуулган байв”¹⁷ хэмээснээс үзэхэд, 1913 оны Өвөр Монголын байлдаан нь голдуу тус хоёр чуулганд болсон мэт ойлгогдоно. Үнэндээ Богд Хаант засгийн газрын өмнө зүг явуулсан бодлого нь зөвхөн Шилийн гол, Улаанцавт хандсан, энэ хоёр чуулганаас цааш цэрэг оруулахгүй гэсэн хэрэг бус болов уу. Хэдийгээр Ар Монголын цэрэг эхний ээлжинд Шилийн гол, Улаанцаваар орж ирсэн боловч дараа дараагаар байлдааны бүсийг өргөтөхийн сацуу өвөр чуулганы бусад хошуудаас бас их хэмжээний цэрэг татаж байжээ. Чухамдаа 1913 оны байлдаан нь Өвөр Монголын ихэнх хэсгийг хамарсан гэдгийг Ар Монголын талаас Засагт, Жалайд, Хишигтэн жич Зуу-Удын бусад хошуудад буу зэвсэг өгч байсан мэдээ ба ялангуяа Цахар, Зуу-Уд, Жирэмийн нутаг дээр байлдаж байсан түүхийн баримтуудаас гэрчилж болох юм уу гэж бодно.

Түүнчлэн Өвөр монголын талаас Богд Хаант засгийн газарт дагаар орохоо илэрхийлээгүй хошуудыг дагаар орохоо илэрхийлсэн хошуудтай харьцуулбал, дагаар орохоо илэрхийлээгүй хошуун доторхи хятад хүн амын харьцлаар өндөр байна¹⁸ хэмээх дүгнэлт оновчтой эсэхэд бодуштай тал бас буй. Бас тус номын 70-р талын зүүлт 28-ын агуулга нь уг сурвалжийн тэмдэглэлтэй зөрсөн, мөн 141-р талд дурдагдах 1 сарын 5-ны өдрийн бичгийн он тодорхойгүй зэрэг алдаа байна. Тус номд зохиогчийн өөрөө нягталж зурсан маш олон тодорхой сайхан газрын зураг буй. Эдгээрийг гарчигийн жагсаалт хийгээд номын гарчигт оруулсан бол зохистой. Зургийн тухайд, 81-р тал дахь Зураг 2-ын Харбин хэмээх хятад үгийн нэг үсэг нь ташаарчээ.

Тус ном бол зохиогчийн Васэда их сургуульд дэвшүүлсэн докторын эрдмийн зэрэг горилсон өгүүлэл (2009-2010 он)-ийн үндсэн дээр бүтсэн юм. Сүүлийн үед, докторын зэрэг горилсоны дараахан зохиолыг ном болгон хэвлүүлж байгаа байдал аль оронд ч цөөн бус харагдаж байна. Гэвч үнэхээр ийм өндөр түвшинд хүрч чадсан бүтээл цөөн байдаг гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй буй за. Ялангуяа доктор М.Тачибанагийн энэ ном аль нэг хэмжээгээр уншигчдыг хүчтэй нөлөөлж олон улсын монгол түүх судлалын хүрээнд анхаарал татахуйц өндөр амжилт гаргасан бүтээл болох учраас түүнийг докторын өгүүллийн энгийн зэрэглэлд тавьж ярьж болохгүй.

16. Тянь Жихө, Фэн Шиожүн. “Иргэн улсын эхний онуудад болсон монгол хошуудын тусгаар тогтнолын тухай судлал”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1991 он.

17. Зүүлт 1, т.189-190.

18. Зүүлт 1, т.227

Хятадын “Зуун шилдэг” өгүүллийн дотор ч ийм дорвитой хүндтэй бүтээл хэд байх бол уу? хэмээн сэтгэгдэнэ.

Тус ном нь бидний хэвшиж заншсан “Хувьсгалын түүх”-ийн ном буюу ойворгон түүхчдийн зохиол бүтээлээс огт өөр утга агуулга бүхий “Засаж бичигдсэн түүх”-ийн агуулгаар гойд ялгарахуйц болсон байна. Зохиолын хамарсан хэвчээгээр өргөн бөгөөд түүх уншигчдын идэвх сонирхлыг сэргээх шинэ мэдлэг цөөн бус буй.

Нэн чухал нь зохиогч бээр монгол, япон, орос, хятад, англи, герман зэрэг олон хэл дээр байгаа баялаг эх сурвалжуудыг дэлгэрэнгүй ашиглаж чаджээ. Тэр дундаа урьдын хүмүүсийн анхааралдаа аваагүй ар өвөр Монголын засаг ноёдын хоорондох нааш цааш илгээсэн бичгүүд ба гадаад харилцааны тухай цөөн бус архивын баримтуудыг судалгааны эргэлтэд оруулжээ. Тийм учраас тус бүтээл япон, монгол хэл төдийгүй орос, англи хэлээр хэвлүүлэх нь чухал хэмээн үзэж байна.

(Тус шүүмж нь анх Гүн ухаан нийгмийн шинжлэх ухаан, өвөр Монголын их сургууль, Эрдэм шинжилгээний сэтгүүл №1, 2013, т.110-118-д монгол бичгээр хэвлэгдсэн болно.)